



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/65

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах хугацаанд Цэнхэрмандал сумын "Хэрлэн гүүр", "Дивизын гарам", Хэрлэн баян-Улаан тосгоны "Аягын гарам" зэрэг 3 цэгт 2021 оны 2 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл 28 хоногийн хугацаанд ажиллах 17 алба хаагчдын бичиг хэрэг, хоол, 3 автомашины шатах тослох материалын зардал болон аймгийн "Шуурхай штаб"-ын жижүүрт үүрэг гүйцэтгэж буй 5 алба хаагчдын бичиг хэрэг, хоолны зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Хэрлэн, Бор-Өндөр сумын "Төмөрт овоо", "Отволь", "М Ойл" цэгийн хяналтын 3 постод үүрэг гүйцэтгэж буй 7 алба хаагчдын хоол, тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг Хэрлэн, Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулсугай.

3. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 15.900.000 /арван таван сая есөн зуун мянга/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010201

02 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл				Дүн
	Бичиг хэргийн зардал	Холбооны зардал	Шатахууны зардал	Хоолны зардал	
Цагдаагийн газар		86400	2604000	9520000	12210400
Онцгой байдлын газар	200000		155000	3334600	3689600
Дүн	200000	86400	2759000	12854600	15900000